



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 11366.

Арвайхээр сум

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 68 дугаар дүгнэлтийн дагуу Өвөрхангай аймаг дахь нисэх буудалд 2023 онд хэрэглэгдэх шатахуун тус тендерийн 1 дүгээр багц Арвайхээр нисэх буудлын хэрэгцээний шатахуун нийлүүлэх 23,000,000 (хорин гурван сая) төгрөгөөр “НИК” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тус тендерийн 2 дугаар багц Богдын Далан ОУӨС-ын хэрэгцээний шатахуун нийлүүлэх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул тендерийг хүчингүй болгосугай.

3. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Өвөрхангай аймгийн Нисэх буудал (А.Мөнхбат)-д даалгасугай.

4. Шалгарсан аж ахуйн нэгжид гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Өвөрхангай аймгийн Нисэх буудал (Б.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0710

D:My Doc. Zahiramj. Zasag darga